

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 18 2023 оны 4-р сар

■ ХААЛТЫН ЗАРДАЛ ТООЦООЛСНООР ЯМАР ДАВУУ ТАЛУУД БИЙ БОЛОХ ВЭ?

Уурхайн хаалт, нөхөн сэргээлтний зардлыг тооцоолж, хуримтлуулах нь хариуцлагатай уул уурхайг хэрэгжүүлэх нэг чухал үзүүлэлт болдог. Хаалтын зардлыг тооцооноор уул уурхайн компаниудын хувьд хууль эрх зүйн шаардлагыг биелүүлэх, байгаль орчныг хамгаалах хариуцлагаа хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулахаас гадна компанийн санхүү, бизнесийн төлөвлөлтийг сайжруулж, нэр хүндийг өсгөх давуу талуудыг бий болгодог. Уурхайн хаалтыг эрт төлөвлөх, ингэхдээ ард иргэд болон бусад оролцогч талуудтай нягт хамтран ажиллах нь уурхайн компаниудад хаалтын явцад шаардагдах өртөг зардлыг урьдчилан тооцоолох, хөрөнгө хуваарилж, хуримтлуулах боломжийг олгодог.

Уурхайг амжилттай хаахын тулд хаалтын зардлыг тооцох хэд хэдэн шалтгаан бий. Эдгээрийг доор тайлбарлав.

Хуулийн хэрэгжилт: Уул уурхайн компаниуд олборлолтын үйл ажиллагаа нь дууссаны дараа уурхайн талбайг хүн ам, хүрээлэн буй орчинд аюулгүй байхаар экологийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгөх хуулийн хариуцлага хүлээдэг. Хаалтын журмыг биелүүлээгүй тохиолдолд торгууль, хуулийн хариуцлага хүлээх эрсдэлтэй. Дээрх эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд уул уурхайн компаниуд хаалтын зардлыг эрт, үнэн зөв тооцож, хаалтын үйл ажиллагааг хангалттай санхүүжүүлэх нь чухал юм.

Байгаль хамгаалал: Уурхайн хаалтын зардлыг тооцоолсноор компанийн хувьд уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад шаардлагатай хөрөнгийг эрт төлөвлөж, хуваарилахад тусалдаг. Эдгээр үйл ажиллагаа нь химийн бохирдлыг саармагжуулах, эвдрэлд өртсөн газрыг нөхөн сэргээх, усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, мөн хаалтын дараах арчилгаа тордлогоо зэрэг үйл ажиллагаанаас бүрдэнэ. Уурхайн талбайг зохих ёсоор төлөвлөж, хаагаагүйгээс үүдэн хөрс, усны бохирдол үүсэж, хүрээлэн буй орчны экосистем, нутгийн иргэдийн амьдралд удаан хугацаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.



Зураг 1: Төслийн олон улсын зөвлөх Майк Поссентэ, MERIT төслийн баг, Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн инженер, техникийн ажилтнууд хамтран Салхитын уурхайн талбай дээр Эрсдэлийн үнэлгээ хийж үеэр

Санхүүгийн төлөвлөлт: Уурхайн хаалтын зардлыг эрт тооцоолох нь уурхайн компаниудын хувьд урт хугацаанд санхүүгийн удирдлага, чадавхыг зөв төлөвлөхөд ихээхэн нөлөө үзүүлдэг. Уурхайн хаалтын зардлыг үнэн зөв тооцооноор компанийн хувьд хөрөнгө, санхүүгээ зөв төсөвлөх, хуваарилах боломж бүрдэж, уурхайг хаах үед хаалтын зардлыг нөхөх хангалттай хөрөнгө буй эсэхийг баталгаажуулдаг.

Нэр хүнд: Уурхайн талбайг зохих ёсоор хаагаагүй эсвэл хууль эрх зүйн шаардлагыг дагаж мөрдөөгүй уул уурхайн компаниудын нэр хүнд унах эрсдэлтэй байдаг. Уурхайг зохих ёсоор хаах нь тухайн компанийн хувьд байгаль орчны тогтвортой байдал, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг эрхэмлэдэг болохыг харуулж буй зүйл юм.

■ САЛХИТЫН МӨНГӨНИЙ УУРХАЙН ХААЛТЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭГ ЭЦЭСЛЭН БОЛОВСРУУЛАВ

Уурхайн хаалтын төлөвлөлтийн багийн гишүүд төслийн олон улсын зөвлөх корпораци СиПиПи Энвэйронменталын удирдан явуулсан цуврал семинарт оролцон, хаалтын хяналт-шинжилгээний хүрээтэй танилцаж, шат дараалсан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав. Төлөвлөлтийн багийн гишүүд уурхайн хаалт, нөхөн сэргээлтний явцыг үнэлэх зорилгоор хаалтын зорилт бүрт тохирсон шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан, хэлэлцүүлсэн юм. СиПиПи Энвэйронментал нь уг сонгосон шалгуур үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, шалгуур үзүүлэлт бүрийг хянах, дасан зохицох менежментийн стратегийг боловсруулах зорилгоор Эрдэнэс Силвер Ресурс компанийн техникийн мэдээлэл бүхий загвар боловсруулав. Хяналт-шинжилгээний эцсийн хүрээг хүснэгтэд үзүүлэв.

Хяналт-шинжилгээний агуулгыг Монгол улсад мөрдөгддөг хууль эрх зүйн шаардлагууд болон стандартын (MNS) дагуу боловсруулсан болно. Түүнчлэн тус хүрээг боловсруулахдаа олон улсын сайн туршлагыг харгалзан үзсэн. Үүнд: эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн ялгаатай хэрэгцээнд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх; уур амьсгалын өөрчлөлтийн болзошгүй нөлөөллийг хянах; орон нутгийн иргэд, ажиллах хүчний нийгэм, эдийн засгийн хэрэгцээг хангах гэх мэт.

Уурхайн хаалтын төлөвлөгөөний Мониторингийн стратегийн бүлэгт үндсэн баримт бичгээс гадна шалгуур үзүүлэлт тус бүрийн техникийн мэдээллийн загвар, мониторингийн хуваарь, ургамалжилт, хөрсний үзүүлэлтүүдийн хяналтын талбайн зураг зэргийг багтаасан болно.

**Зорилго, зорилт, шалгуур, үзүүлэлтүүдийн тодорхойлолыг багтаасан Хаалтын мониторингийн тогтолцоог боловсруулах үйл явцыг 2023 оны 2-р сарын мэдээнээс харна уу.*

Хүснэгт 1: Хаалтын хяналт-шинжилгээний хүрээ (сүүлийн байдлаар)

ЗОРИЛГО 1: Нөлөөлдөд өртсөн талбайг байгалийн унаган төрхөд ойртуулж, нутгийн иргэдийн уламжлалт газар ашиглалтад зориулан нөхөн сэргээх				
Зорилт 1: Нөхөн сэргээсэн талбай нь аюулгүй байдлыг хангасан байна				
Шалгуур үзүүлэлт	1.1	Газар хэлбэршүүдэлт нь геотехникийн тогтворжилтыг хангасан байх		
	Шалгуур үзүүлэлт	1.1.1	Налуугийн тогтворжилт	
		1.1.2	Хөрсний суулт, нягтшил	
		1.1.3	Элэгдэл эвдрэл	
	1.2	Нөхөн сэргээсэн талбай нь хүн ам, хүрээлэн буй орчинд физик аюул эрсдэл учруулахгүй байх		
	Шалгуур үзүүлэлт	1.2.1	Үүсмэл нуурын усны хэмжилт	
		1.3	Нөхөн сэргээсэн талбай нь хүн ам, хүрээлэн буй орчинд химийн бохирдол, эрсдэл учруулахгүй байх	
	Шалгуур үзүүлэлт	1.3.1	Хүчиллэг урсац	
		1.3.2	Хучилт хийсэн хөрсөнд химийн хортой болон аюултай бодис агуулагдаагүй байх	
	1.4	Усны чанар		
Шалгуур үзүүлэлт	1.4.1	Газрын доорх усны чанар		
	1.4.2	Үүсмэл нуурын усны чанар нь тухайн бүс нутгийн гүний усны чанарын үзүүлэлтүүдтэй ойролцоо байх		
	1.4.3	Цаашид ашиглахгүй гүний хулгуудыг битүүмжилж хаах		
Зорилт 2: Нөхөн сэргээсэн талбайд өөрийгөө тэтгэх экосистемийн тогтолцоо бүрдсэн байх				
Шалгуур үзүүлэлт	2.1	Нөхөн сэргээсэн ургамлын бүрхэвч нь эргэн тойрны эвдрэлд өртөөгүй газрын ургамлын бүлгэмдэлтэй төстэй байх		
	Шалгуур үзүүлэлт	2.1.1	Ургамлын бүрхэвч нь нөхөн сэргээсэн талбайн >30%-д байх	
		2.1.2	Ургамлын зүйлийн бүрдлийг бий болгох	
	2.2	Шимт хөрсний хучилт		
	Шалгуур үзүүлэлт	2.2.1	Хөрсний чанар	
		2.2.2	Хөрс хучилтын зузаан	
	2.3	Нөхөн сэргээсэн талбай нь биологийн олон янз байдлын амьдрах орчныг тэтгэдэг байх		
	Шалгуур үзүүлэлт	2.3.1	Зэрлэг ан амьтад идээшиж буй байдал	
		2.4	Нөхөн сэргээсэн талбай нь уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, дасан зохицохуйц байх	
	Шалгуур үзүүлэлт	2.4.1	Газар хэлбэршүүдэлт нь үер усны эрсдэлд тэсвэртэй байдал	
		2.4.2	Хүлэмжийн хийн шингээлт (Бэлчээрийн экологийн чадавх, бүтээмжийг хэмжих)	
	2.5	Газрын доорх усны ордуудын нөхөн сэлбэгдэх нөхцөлийг дэмжих		
	Шалгуур үзүүлэлт	2.5.1	Гүний уст давхаргын усны түвшний үзүүлэлт	
		2.6	Хаалтын дараах газар хэлбэршүүдэлтийг тухайн бүсийн байгалийн унаган төрхөд дүйцүүлсэн байдал	
Шалгуур үзүүлэлт	2.6.1	Байгалийн унаган төрхийг хадгалсан ус зайлуулах сүлжээ байгуулах		
	Зорилт 3: Уламжлалт газар ашиглалтыг дэмжихүйц байхаар нөхөн сэргээх			
Шалгуур үзүүлэлт	3.1	Бэлчээрийн ургац, ургамлын нөмрөгийн бүрхэц нөхөн сэргээсэн байна		
	Шалгуур үзүүлэлт	3.1.1	Бэлчээрийн ургамлын зүйлийн бүрдэл	
		3.1.2	Бэлчээрийн экологийн чадавх, үржил шим	
	3.2	Нутгийн ургамлыг эмийн болон хүнсний зориулалтаар ашиглах боломжтой болно		
	Шалгуур үзүүлэлт	3.2.1	Бэлчээрийн ургамлын зүйлийн бүрдэл	
3.2.2		Бэлчээрийн экологийн чадавх, үржил шим		
ЗОРИЛГО 2: Уурхайн дэд бүтцийг түшиглэн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх				
Зорилт 4: Уурхайн ажилчид болон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал уурхай хаагдсан үеийнхтэй дүйцэхүйц эсвэл сайжирсан байна.				
Шалгуур үзүүлэлт	4.1	Уурхайн ажилчдын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудал		
		Шалгуур үзүүлэлт	4.1.1	Байгууллага дотроо шилжин ажилласан ажилчид
			4.1.2	Ажлаас чөлөөлөгдсөн ажилчид
			4.1.3	Сургалтад хамрагдаж, мэргэжил дээшлүүлсэн ажилчид
	4.1.4	Ажилчдын жендэрийн онцлог хэрэгцээг харгалзаж үзсэн байдал		
	4.2	Уурхайн нөлөөллийн бүсийн иргэдийн эдийн засгийн нөхцөл байдал		
		Шалгуур үзүүлэлт	4.2.1	Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилт
			4.2.2	Орон нутгийн иргэдийг сургах
4.2.3			Хаалтын дараа дахин ашиглуулахаар үлдээсэн барилга байгууламжууд	
4.2.4	Шилжилтийн үеийн эдийн засгийн үр өгөөж			

■ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД:

Салхитын Уурхайн Хаалтын Төлөвлөгөөний Жишиг төслийн ажил зуны эхэн сард дуусах дөхөж байгаа энэ үед MERIT багийнхан төслийн явцын талаар оролцогч талуудад мэдээлэл өгөх, орон нутгийн иргэдэд мэдээлэх, Уурхайн хаалтын төлөвлөгөөний баримт бичгийг эзэмшигч Эрдэнэс Силвер Ресурс ХХК-д албан ёсоор хүлээлгэн өгөх зорилгоор төслийн сүүлийн гурван арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байна. Үүнд:

- Гол оролцогч талуудын сүүлийн уулзалт – Улаанбаатар хот, 2023 оны 5 сарын 30
- Иргэдэд зориулсан хэлэлцүүлэг #3 – Дундговь аймаг, Мандалговь хот – 2023 оны 6 сарын 13-14
- Уурхайн хаалтын төлөвлөгөөг хүлээлгэж өгөх ёслолын ажиллагаа, хэлэлцүүлэг – Улаанбаатар хот, 2023 оны 7 сарын 3-4

ХОЛБОО БАРИХ

Бид та бүхэнд Салхитын уурхайн хаалтын мэдээ мэдээллийг аль болох сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог билээ. Төслийн оролцогч талуудын санал, сэтгэгдлийг сонсож, бэлтгэж буй мэдээ мэдээллийг уншигчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх нь чухал юм. Тиймээс та бүхэн төслийн сар тутмын мэдээтэй холбоотой санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн захирал
Р.Алтангэрэлтэй имэйл хаягаар холбогдоно уу.
r.altangerel@merit.mn